



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 276

Улаанбаатар

Гадаадад зээлээр суралцуулах,  
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тогтохбаяр овогтой Баттулгыг Батлан хамгаалахын яамны захиалгаар АНУ-ын Вашингтоны их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр, Балхжав овогтой Чингүүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Campbellsville их сургуулийн магистрантурт урлагийн менежментийн чиглэлээр, Цагаанбанди овогтой Буянбаатарыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар АНУ-ын Вирджинийн Олон улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Баясгалан овогтой Мөнхцэцэгийг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт санхүүгийн чиглэлээр, Раднаа овогтой Наранбадралыг Эрүүл мэндийн яамны захиалгаар Япон Улсын Кюсю их сургуулийн магистрантурт дүрс оношлогооны чиглэлээр, Чогсом овогтой Мөнхбаярыг Австрали Улсын Үндэсний их сургуулийн магистрантурт санхүүгийн удирдлагын чиглэлээр, Отгонбаяр овогтой Чулууныг Батлан хамгаалахын яамны захиалгаар АНУ-ын Калифорнийн Олон улсын их сургуулийн магистрантурт төрийн менежментийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 412 дугаар тушаалын Балжир овогтой Хишигтогтохтой холбогдолтой хэсгийн “АНУ-ын Бриджпортын их сургуулийн” гэснийг “Австрали улсын New South Wales их сургуулийн” гэж өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү

00 0021

тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



*Болормаа*

Н.БОЛОРМАА